



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 08 сарын 08 өдөр

Дугаар A/378

Улаанбаатар хот


Монголын уламжлалт анагаах ухааны тусlamж,⁷
үйлчилгээний заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн Газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтыг үндэслэн Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.2.8 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь.

1. Монголын уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээний зааврыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалыг үйл ажиллагаандaa мөрдлөг болгон, хяналт тавьж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, мэргэжилт арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн газар (Я.Буянжаргал)-т, Мэргэжлийн салбар зөвлөл (З.Мэндсайхан)-д тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардагдах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслээр хангах зардлыг жил бурийн төсөвт тусгаж, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт, Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газар (Г.Эрдэмбилэг)-т тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Я.Амаржаргал)-т даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



081445

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 08 сарын 08 өдрийн
1378 дугаар тушаалтын хавсралт

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврын зорилго нь Монголын уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээг Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.2.8 дахь заалт /Тусlamж, үйлчилгээний анхан болон лавлагаа шатлалд уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлэх, экспортод гаргах гарцыг дэмжин “бренд” болгох/-ыг үндэслэн эрүүл мэндийн тогтолцоотой уялдуулан, орчин үеийн анагаах ухаантай хослуулан хэрэглэх замаар эрүүл мэндийн байгууллагуудад уламжлалт анагаах ухааны онол, эмнэлзүйн нотолгоонд сууринсан, үйлчилүүлэгч төвтэй тусlamж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, тасралтгүй үзүүлэхэд оршино.

1.2. Монголын уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээг үзүүлэхэд Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд холбогдох бусад хууль тогтоомж, оношилгоо эмчилгээ, эмнэлзүйн удирдамж болон энэхүү зааврыг мөрдлөг болгоно.

Хоёр. Уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээ

2.1. Уламжлалт анагаах ухааны аргаар анхан болон лавлагаа шатанд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусlamж, үйлчилгээг үзүүлнэ.

2.2. Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хүрээнд хүн амд уламжлалт ёс заншил, зан үйл, цаг улирал, орчин, бусад шалтгаан, идээ ундаа, явдал мөртэй холбогдуулан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн дадал, мэдлэг олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмол хийнэ.

2.3. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд уламжлалт анагаах ухааны оношилгоо, идээ ундаа, явдал мөр, эм, заслын аргаар төрөлжсөн, мэргэшсэн тусlamж, үйлчилгээг холбогдох стандарт, эмнэлзүйн зааврын дагуу чанартай үзүүлнэ.

2.4. Бие хүний өвөрмөц чанарт идээ ундаа, ахуй үесийн явдал мөрийг тохируулан дараах өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх тусlamж, үйлчилгээг үзүүлнэ:

- 2.4.1. З гэмийн өвчин /Хий, Шар, Бадган/;
- 2.4.2. Дотор өвчин;
- 2.4.3. Халуун өвчин;
- 2.4.4. Цээжин биеийн өвчин;
- 2.4.5. Цул савын өвчин;

- 2.4.6. Нууцын өвчин;
 - 2.4.7. Хэсэг бусаг өвчин;
 - 2.4.8. Хамт төрсөн яр, шархыг анагаах;
 - 2.4.9. Нялхсын өвчнийг анагаах;
 - 2.4.10. Эмэгтэйн өвчнийг анагаах;
 - 2.4.11. Адын өвчнийг анагаах;
 - 2.4.12. Мэсийн шархыг анагаах;
 - 2.4.13. Хорын өвчнийг анагаах;
 - 2.4.14. Хөгшдийг анагаах;
 - 2.4.15. Хүчжүүлэх;
- 2.5. Өвчин эмгэгийг эрүүлжүүлэх бие, хэл, сэтгэлийн цогц тусlamж, үйлчилгээг үзүүлнэ.

Гурав. Уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээ үзүүлэх байгууллага

3.1. Уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээг дараах эрүүл мэндийн байгууллагууд үзүүлнэ:

3.1.1 Уламжлалт анагаах ухааны чиглэлээр төрөлжсөн мэргэшлийн тусlamж, үйлчилгээ үзүүлдэг улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд.

3.1.2 Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1 /15.1.6, 15.1.9-өөс бусад/-д заасан эрүүл мэндийн байгууллагууд.

Дөрөв. Уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үүрэг, үйл ажиллагаа

4.1. Нийтлэг үүрэг, үйл ажиллагаа:

4.1.1 Монгол улсад мөрдөгдөж буй эрүүл мэндийн холбогдолтой хууль тогтоомж, тушаал, журам заавар, холбогдох стандартын хэрэгжилтийг ханган ажиллаж, хүн амд чанартай тусlamж, үйлчилгээг үзүүлнэ;

4.1.2 Уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай өрөө, тасалгаа, эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийг холбогдох стандартад заасны дагуу бүрдүүлэн тусlamж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх нөхцөлөөр хангана;

4.1.3 Уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээ үзүүлэх багийг стандартын дагуу зохион байгуулж, шаардлагатай хүний нөөцийг зөв зохистой бүрдүүлж ажиллана;

4.1.4 Уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээ үзүүлэх үйлчлүүлэгчийг хүлээн авах, бүртгэх, оношлох, эмчлэх, эмнэлэг хооронд шилжүүлэх, нэгтгэн мэдээлэх, тайлагнах, хянах үйл ажиллагааг тасралтгүйгээр хэрэгжүүлэн ажиллана;

4.1.5 Тусlamж, үйлчилгээг батлагдсан зааврын дагуу үзүүлнэ;

4.1.6 Тусlamж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үүднээс “Уламжлалт анагаах ухааны зонхилон тохиолдох өвчний ангилал”-ын дагуу үйлчлүүлэгчийн өвчний мэдээлэл, эмчилгээний тухай эмнэлгийн байгууллага болон эрүүл мэндийн даатгалын байгууллага хоорондын мэдээллийн нэгдсэн санг бий болгоно;

4.1.7 Уламжлалт анагаах ухааны эмч, сувилагч, эм зүйчийг мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалтанд тогтмол хамруулж, мэдлэг, ур чадвар, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна;

4.1.8 Уламжлалт анагаах ухааны аргаар хүн амыг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг бусад аж ахуй, нэгж байгууллага, ард иргэд, үйлчилгээгчтэй хамтран зохион байгуулна;

4.2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, клиник нь уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг гэрийн, амбулаторийн, өдрийн эмчилгээний хэлбэрээр үзүүлж, тусламж, үйлчилгээний зааврыг үндэслэн дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээх бичгээр шилжүүлнэ.

4.3. Уламжлалт анагаах ухааны эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, сувилал, бүсийн оношилгоо, эмчилгээний төв нь тасаг, нэгжийн болон бие даасан зохион байгуулалттай ажиллана. Эдгээр эрүүл мэндийн байгууллага нь уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг орчин үеийн анагаах ухаантай хослуулан амбулаторийн, өдрийн, хэвтүүлэн эмчлэх эмчилгээний хэлбэрээр үзүүлж, тусламж, үйлчилгээний зааврыг үндэслэн дараагийн шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээх бичгээр шилжүүлнэ.

4.4. Уламжлалт анагаах ухааны тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг багаар үзүүлдэг бие даасан бүтэц, зохион байгуулалттай байна. Эдгээр эрүүл мэндийн байгууллага нь уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг амбулаторийн, өдрийн, хэвтүүлэн эмчлэх эмчилгээний хэлбэрээр үзүүлж, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэн бусад эрүүл мэндийн байгууллагыг лавлагаа, мэргэжил, арга зүйгээр ханган ажиллана.

Тав. Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлэх хэлбэр

5.1. Урьдчилан сэргийлэх: Уламжлалт анагаах ухааны онолд суурилан хувь хүний өвөрмөц чанар, идээ ундаа, явдал мөрийн онцлог, цаг улирлын хөдлөл зүйд тулгуурлан өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, амьдралын буруу хэвшлээс шалтгаалсан эрсдэлт хүчин зүйлсийг тооцох, зөв дадал хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.

5.2. Оношлох: Асуух /хөдөлгөх нөхцөл, өвдөх байдал, туслах, хорлох явдал мөр/, Үзэх /5 цэцэг эрхтэн, шээс/, Хүрэлцэх /судас, бэлчир орон/ бүхий уламжлалт оношилгооны арга болон орчин үеийн анагаах ухааны лаборатори, багажийн шинжилгээний аргаар үйлчилгээгчийн эрүүл мэндийн байдалд үнэлгээ өгөх, өвчиний шалтгаан, нөхцөл, хувирал болон эмчилгээний явц, үр дүнг тодорхойлно.

5.3. Эмчлэх: Өвчиний шалтгаан, хөдөлгөх нөхцөл, орох үүд, орших орон, ялгал, хувирал, өвчиний хурах, хөдлөх, амарлиулах үеийг үндэслэн идээ ундаа, явдал мөр, эм, засал, гүрэм, бясалгалын өрөндгөөр өвчиний бэлгэ чанарыг амарлиулан, арилган засна.

Зургаа. Монголын уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээ үзүүлэх заавар

Хүснэгт 1.

Тусlamж үйлчилгээ үзүүлэх байгууллага	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэг /үзүүлэх тусlamж, үйлчилгээ/			Нэгдсэн, төв, тэрэлжсэн мэргэшлийн эмнэлэгт үзүүлэх тусlamж, үйлчилгээ
Хэлбэр	Гэрээр үзүүлэх тусlamж, үйлчилгээ	Амбулаторийн тусlamж, үйлчилгээ	Өдрийн эмчилгээ	Хэвтүүлэн эмчлэх эмчилгээ
Үйлчлүүлэгч	Эмчийн өгсөн заавар нь гэртээ хийх боломжтой	Хэвтрийн дэглэм сахих заалтгүй	Хэвтрийн дэглэм сахих заалтгүй	Хэвтэн эмчлүүлэх шаардлагатай
Эмчилгээ	<u>Эмчилгээ:</u> хувь хүний өвөрмөц чанар, цаг улиралд нь тохирсон идээ ундаа, амьдралын хэв маягийн талаарх өвчинеес урьдчилан сэргийлэх зөвлөгөө, эм болон засал. <u>Засал</u> <u>эмчилгээнд:</u> хэсэг газрын бария, ороох дэвтээлгэ, жин засал, шивүүр.	<u>Эмчилгээ:</u> /Стандарт, зааврын тохирох/ хувь хүний өвөрмөц чанар, цаг улиралд нь тохирсон идээ ундаа, амьдралын хэв маягийн талаарх зөвлөгөө, эм болон засал. <u>Засал эмчилгээнд:</u> соруул, бария заслын бүх төрөл, төөнө 3 төрөл, ороох дэвтээлгэ, зүү 2 төрөл, жин засал, шивүүр.	<u>Эмчилгээ:</u> /Стандарт, зааврын дагуу тохирох/ хувь хүний өвөрмөц чанар, цаг улиралд нь тохирсон идээ ундаа, амьдралын хэв маягийн талаарх зөвлөгөө, эм болон засал. <u>Засал эмчилгээнд:</u> соруул, бария, төөнө, дэвтээлгэ, зүү, бөөлжүүлэг, туулга, хамрын эм, зөөлөн шимт, нируха, самнуур, шивүүр, хануур бүх судас, жин засал, шархны гадар, дотор эмчилгээ.	<u>Эмчилгээ:</u> /Стандарт, зааврын дагуу тохирох засал/ хувь хүний өвөрмөц чанар, цаг улиралд нь тохирсон идээ ундаа, амьдралын хэв маягийн талаарх зөвлөгөө, эм болон засал. <u>Засал эмчилгээнд:</u> соруул, бария, төөнө, дэвтээлгэ, зүү, бөөлжүүлэг, туулга, хамрын эм, зөөлөн шимт, нируха, самнуур, шивүүр, хануур бүх судас, жин засал, шархны гадар, дотор эмчилгээ.
Давтамж	1-3 хоног	5-7 хоног	5-7 хоног	7-10 хоног
Гам дэглэм	Хооллолт, өдөр тутмын хэв маяг энгийн дэглэмтэй	Хооллолт, өдөр тутмын хэв маяг хөнгөн дэглэмтэй	Хооллолт, өдөр тутмын хэв маяг хөнгөн дэглэмтэй	Хооллолт, өдөр тутмын хэв маяг хатуу дэглэмтэй

Долоо. Монголын уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээний хэлбэр

Хүснэгт 2.

№	Уламжлалт анагаах ухааны тусlamж, үйлчилгээний хэлбэр		Гэрийн эмчилгээ	Амбулаторийн эмчилгээ	Өдрийн эмчилгээ	Хэвтүүлэн эмчлэх эмчилгээ
1.	Оношилгоо	Уламжлалт анагаах ухааны оношилгоо /асуух, үзэх, хүрэлцэх/	+	+	+	+
2.	Эмчилгээ	Идээ ундаа /Хувь хүний өвөрмөц чанар, цаг улирлын хөдлөл зүйд тохирсон/	+	+	+	+
		Явдал мөр / Хувь хүний өвөрмөц чанар, цаг улирлын хөдлөл зүйд тохирсон/	+	+	+	+
		Бясалгал			+	+
		Гүрэм	+	+	+	+
		Сэтгэл засал	+	+	+	+
		Дасгал хөдөлгөөн	+	+	+	+
3.	Эм	Амарлиулах эм				
		Тан	+	+	+	+
		Талх	+	+	+	+
		Үрэл	+	+	+	+
		Зуурмал		+	+	+
		Тосон эм	+	+	+	+
		Үнсэн эм	+	+	+	+
		Хандан эм	+	+	+	+
		Архин эм			+	+
		Туйплан эмчилгээ				+
		Арилгах эм				
		Хэвллийн туулга			+	+
		Судсан туулга				+
		Бөөлжүүлэг			+	+
		Хамрын эм			+	+
		Зөөлөн шимт			+	+
		Нируха			+	+
4.	Засал	Зөөлөн засал				

	Жин засал	+	+	+	+
	Ороох дэвтээлгэ	+	+	+	+
	Рашаан дэвтээлгэ			+	+
	Ууран дэвтээлгэ			+	+
	Усан дэвтээлгэ			+	+
	Арьслах, сэвслэх				+
	Шавар				+
	Шархны гадна, дотно эмчилгээ			+	+
	Бария засал: Бүх биесийн бария	+	+	+	+
	Хэсэгчилсэн бария (Толгой, хүзүүний, гар хөлийн, их биесийн)	+	+	+	+
	Сүүн бария			+	+
	Шөлөн бария			+	+
	Халуун тосон бария			+	+
	Рашаант бария			+	+
	Шаварт бария				+
	Эмт бария			+	+
	Арвайн бария			+	+
	Ясны бария				+
	Даран бария				+
	Суваг хэрдхийн дагуух бария				+
	Тархины доргилтын бария	+	+	+	+
	Бөөр, савны доргилтын бария			+	+
	Гар засал				+
	Монгол төөнө	+	+	+	+
	Харандаан төөнө	+	+	+	+
	Эсгий төөнө	+	+	+	+
	Цахилгаан төөнө		+	+	+
	Чихний төөнө			+	+
	Соруул: Энгийн соруул	+	+	+	+
	Гулгуур соруул		+	+	+

		Ширүүн засал			
		Хануур засал:		+	+
		Толгойн судас			
		Хүзүүний судас		+	+
		Гарын судас	+	+	+
		Хөлийн судас	+	+	+
		Их биеийн судас		+	+
		Бэрх оньстий судас			+
		Самнуур засал	+	+	+
		Шивүүр засал	+	+	+
		Хатгуур засал /Түрэм/	+	+	+
		Зүү засал: Биеийн зүү	+	+	+
		Усан зүү		+	+
		Цахилгаан зүү		+	+
		Чихний зүү	+	+	+
		Гарын зүү	+	+	+
		Толгойн зүү			+
		Арьсны зүү			+
		Бүлээн зүү		+	+
		Гурвалжин зүү	+	+	+
		Бөөлжүүлэг засал		+	+
		Туулга засал		+	+
5.	Нийгмийн эрүүл мэнд, өвчинөөс урьдчилан сэргийлэх	Монгол орны ёс заншил, цаг улирлын хөдлөл зүй болон хувь хүний өвөрмөц чанар, онцлогт тохирсон 4 төрлийн ерөндөгийн хэрэглээ	+	+	+

.....оо.....